



## **ИНД - 43**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Техник үйлчилгээний ерөнхий дүрэм**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-43 нь техник үйлчилгээний болон ИНД-21-ийн дагуу олгосон Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байхыг ИНД-91-д шаардсан агаарын хөлөг болон агаарын хөлөгт суурилуулах бүрдэл хэсгийн техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-43-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-43, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

**Өөрчлөлтийн түүх****Хүчинтэй огноо**

Анхны боловсруулалт	2002 оны 09 сарын 12
Нэмэлт, өөрчлөлт 1	2008 оны 02 сарын 29
Нэмэлт, өөрчлөлт 2	2008 оны 05 сарын 30
Нэмэлт, өөрчлөлт 3	2008 оны 09 сарын 11
Нэмэлт, өөрчлөлт 4	2010 оны 04 сарын 16
Нэмэлт, өөрчлөлт 5 (Шинэчлэлт)	2018 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-43-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 43 A.14-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>6</b>
43.1. Зорилго .....	6
43.3. Тодорхойлолт ба товчлол .....	6
43.5. Техник үйлчилгээний баримт бичгийг хуурамчаар үйлдэх, нөхөн үйлдэх, эсхүл өөрчилж засварлах .....	6
<b>В Бүлэг - Техник үйлчилгээ</b> .....	<b>7</b>
43.51. Техник үйлчилгээ хийх этгээд .....	7
43.53. Техник үйлчилгээний гүйцэтгэл.....	8
43.54. ИНД-145-ын дагуу шаардсан техник үйлчилгээ .....	9
43.55. Их засварын бүртгэл хөтлөх.....	11
43.57. Нөөц .....	11
43.59. Радио станцын тест болон үзлэг.....	11
43.61. Өндөр-хэмжигч системийн тест болон үзлэг .....	11
43.63. SSR транспондерийн тест болон үзлэг .....	11
43.65. Ослын байршил дамжуулагч (ELT), агаарын хөлгийн ослын байршлийн системийн (AELS) тест болон үзлэг .....	11
43.67. Үл эвдэх сорил .....	12
43.69. Техник үйлчилгээний бүртгэл хөтлөх.....	12
<b>С Бүлэг - Ашиглалтад шилжүүлэх</b> .....	<b>14</b>
43.101. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд.....	14
43.103. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх шаардлага .....	14
43.105. Техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх 16	
43.107. Ажиллагаагүй төхөөрөмж.....	16
43.109. Гэмтэл.....	17
43.111. Нөөц.....	17
43.113. Удирдлагын системийн аюулгүй байдлын давхар үзлэг .....	17
43.115. Хөдөлгүүрийн үзүүлэлтийн шалгалт.....	19
<b>Д Бүлэг - Нислэгт тэнцэх чадварын үнэлгээ</b> .....	<b>19</b>
43.151. Үнэлгээ хийх этгээд.....	19
43.153. Үнэлгээний шаардлага .....	20
43.155. Үнэлгээг баталгаажуулах.....	21
<b>Е Бүлэг - Том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа тохирлыг гэрчилгээжүүлэх</b> .....	<b>22</b>
43.201. Зорилго .....	22
43.203. Тохирлыг гэрчилгээжүүлэх этгээд .....	22
43.205. Гэрчилгээжүүлэх шаардлага .....	23
43.207. Гэрчилгээжүүлэлт .....	23
<b>Ф Бүлэг - Тусгай категорийн агаарын хөлгийн техник үйлчилгээ</b> .....	<b>23</b>
43.301. Зорилго .....	23
43.303. Техник үйлчилгээний гүйцэтгэл.....	23
43.305. Их засварын бүртгэл хөтлөх .....	24

43.307. Техник үйлчилгээний бүртгэл хөтлөх .....	24
<b>Хавсралт А - 43.51(b)-гийн дагуу техник үйлчилгээ хийх этгээд .....</b>	<b>25</b>
A.1. Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөг .....	25
A.2. Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаггүй агаарын хөлөг ...	26
<b>Хавсралт В - Агаарын хөлгийн радио станцын үзлэг .....</b>	<b>27</b>
<b>Хавсралт С - Нөөц.....</b>	<b>28</b>
<b>Хавсралт D - Өндөр-хэмжигч системийн тест болон үзлэг .....</b>	<b>29</b>
D.1. Статик даралтын системийн тест:.....	29
D.2. Өндөр-хэмжигчийн тест: .....	29
D.3. Автоматаар даралтын түвшинг мэдээлэгч төхөөрөмж болон АТС транспондер системийн харилцан ажиллагааны тест .....	31
<b>Хавсралт E - АТС Транспондерийн тест болон үзлэг .....</b>	<b>33</b>
E.1. Ерөнхий зүйл .....	33
E.2. Радио хариултын давтамжийн тест .....	33
E.3. Suppression тест .....	33
E.4. Хүлээн авагчийн мэдрэмжийн тест .....	34
E.5. Радио давтамжийн гаралтын оргил чадлын тест .....	34
E.6. Mode S-ын сонгосон дамжуулах сувгийн тусгаарлалтыг тест .....	34
E.7. Mode S-ын хаягийн тест .....	35
E.8. Mode S-ын форматын тест .....	35
E.9. Mode S-ын бүгдийг дуудах асуулгын тест .....	35
E.10. Зөвхөн Mode SATCRBS-ын бүгдийг дуудах асуулгын тест .....	35
E.11. Mode S Squitter-ын тест .....	35
<b>Хавсралт F - Ослын байршил дамжуулагч (ELT), агаарын хөлгийн ослын байршлийн системийн (AELS) тест болон үзлэг .....</b>	<b>36</b>

## **А Бүлэг - Ерөнхий зүйл**

### **43.1. Зорилго**

(a) Энэ Дүрэм нь, энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн техник үйлчилгээ хийх;
- (2) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;
- (3) ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон НТЧ-ын гэрчилгээтэй байхыг ИНД-91-ээр шаардсан агаарын хөлөгт суурилуулах бүрдэл хэсгийн техник үйлчилгээ болон техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;
- (4) бусад холбогдох үйл ажиллагааны дүрэмтэй хамааралтай ИНД-91-ээр шаардсан агаарын хөлөгт суурилуулах хэрэглэл болон төхөөрөмжийн техник үйлчилгээ болон техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэх;
- (5) НТЧ-ын жилийн үнэлгээний.

(b) Техникийн зохицуулалтад өөрөөр заагаагүй бол, Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт, эсхүл Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт суурилуулахаар зорьж байгаа бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд, хэрэв тухайн техник үйлчилгээг дараах байдлаар хийх бол В болон С Бүлгийн шаардлага хамаарахгүй:

- (1) техникийн зохицуулалтын оролцогч тал болох, өөр улсад;
- (2) энэ зүйлийн (b)(1)-д заасан улсаас олгосон ТҮБ-ын гэрчилгээ, эсхүл зөвшөөрлийн хүрээнд, тухайн улсын хяналтад;
- (3) энэ зүйлийн (b)(2)-т заасан тухайн ТҮБ-ын эрх болон холбогдох журмын дагуу;
- (4) тухайн техникийн зохицуулалтад өөрөөр заагаагүй бол, энэ зүйлийн (b)(1)-д заасан тухайн улсын холбогдох техник үйлчилгээний стандарт болон журмын дагуу;
- (5) тухайн техникийн зохицуулалтад заасан аливаа нөхцөлийн дагуу.

### **43.3. Тодорхойлолт ба товчлол**

Энэ дүрэмтэй холбоотой нэр томъёоны тодорхойлолтууд ИНД-1-д агуулагдсан.

### **43.5. Техник үйлчилгээний баримт бичгийг хуурамчаар үйлдэх, нөхөн үйлдэх, эсхүл өөрчилж засварлах**

Аливаа этгээдийг дараах үйлдлийг хийх, эсхүл хийх шалтгаан болохыг хориглоно:

- (1) энэ Дүрмийн аливаа шаардлагын хэрэгжүүлэлтийг харуулахад хэрэглэдэг, эсхүл хадгалдаг болон хийдэг байхыг шаардсан аливаа бүртгэл, эсхүл тайланд хуурамч, эсхүл санаатай худал мэдээлэл оруулах; эсхүл
- (2) энэ Дүрмийн хүрээнд үйлдсэн аливаа бүртгэл, эсхүл тайланг хууран мэхлэх зорилгоор нөхөн үйлдэх, эсхүл өөрчилж засварлах.

## **В Бүлэг - Техник үйлчилгээ**

### **43.51. Техник үйлчилгээ хийх этгээд**

(a) Энэ зүйлийн (b) болон (d)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (e) болон 43.54-г харгалзан, дараах шаардлагыг хангаагүй аливаа этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийхийг хориглоно:

- (1) ИНД-66-гийн дагуу олгосон, тохирох категори болон зэрэглэл бүхий AMEL-ийн хүчинтэй үнэмлэх эзэмшдэг; эсхүл
- (2) хамааралгүй
- (3) ИНД-145-ын дагуу олгосон, тохирох ангилалтай Агаарын хөлгийн ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс тухайн техник үйлчилгээ хийхээр зөвшөөрөгдсөн; эсхүл
- (4) ИНД-66-гийн дагуу олгосон, зохих баталгаажуулсан тэмдэглэл хийсэн хүчинтэй MAC эзэмшдэг; эсхүл
- (5) Монгол Улсаас гадна хийгдэх техник үйлчилгээний хувьд, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрхийн хүрээнд олгосон, тухайн агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгт хүчинтэй AMEL, эсхүл MAC эзэмшдэг; эсхүл
- (6) энэ зүйлийн (a)(1), (3), (4), эсхүл (5)-д заасан тохирох этгээдийн шууд хяналтад тухайн техник үйлчилгээг хийдэг.

(b) Энэ зүйлийн (c)-г харгалзан, энэ зүйлийн (a)-д заасан шаардлагыг хангаагүй боловч дараах аль нэг үнэмлэх эзэмшдэг этгээд нь Хавсралт А.1-д заасан техник үйлчилгээг ИНД-119-ийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөгт, эсхүл Хавсралт А.1 болон А.2-т заасан техник үйлчилгээг иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаггүй агаарын хөлөгт хийж болно:

- (1) ИНД-61-ийн дагуу олгосон, тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчинтэй нисгэгчийн үнэмлэх;
- (2) ИНД-66-гийн дагуу олгосон, хүчинтэй AMEL;

(c) Энэ зүйлийн (b)-д заасан тухайн этгээд нь:

- (1) ИНД-66-гийн дагуу олгосон, тохирох зэрэглэл бүхий хүчинтэй AMEL эзэмшигчийн сургалтад зохих ёсоор хамрагдсан ба агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч техник үйлчилгээ хийхийг бичгээр зөвшөөрсөн байх; эсхүл

(2) энэ Дүрэм, эсхүл ИНД-121, 125, эсхүл 135-д шаардсан, ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд техник үйлчилгээ хийдэг байх агаарын хөлгийн хувьд, тухайн агаарын хөлгийн маягт техник үйлчилгээ хийхээр зохих ёсоор сургалтад хамрагдсан ба ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс олгосон тохирох эрх эзэмшдэг байх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (a)-ийн шаардлагыг хангаагүй этгээд нь, хэрэв дараах шаардлагыг хангасан бол глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийж болно:

(1) глайдерын байгууллагаас олгосон глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх зөвшөөрөлтэй байх; эсхүл

(2) глайдерын байгууллагаас олгосон глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх эрх бүхий этгээдийн шууд хяналтад хийх.

(e) ИНД-47.55(c)-д шаардсан агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн мэдэгдэлд нэр заагдсан техник үйлчилгээний үндсэн гүйцэтгэгчийн сургалтад зохих ёсоор хамрагдаж, зөвшөөрөгдсөн этгээдээс бусад этгээдийг *тусгай категорийн-үзүүлбэрийн* НТЧ-ын гэрчилгээ, эсхүл *тусгай категорийн-хязгаарлагдмал* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт техник үйлчилгээ хийхийг хориглоно.

#### **43.53. Техник үйлчилгээний гүйцэтгэл**

Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд нь дараах үүрэгтэй:

(1) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн НТЧ-ын хадгалалтад шаардлагатай техник үйлчилгээний ажлын талаар зохих мэдлэгтэй байх;

(2) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн задаргаа, үзлэг болон угсралт хийхэд тохиромжтой ажлын байр болон байгууламжийг ашиглах;

(3) дараах аргачлалыг ашиглах:

(i) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн НТЧ-ын хадгалалтын зааварчилгаанд заасан арга, техник болон практик аргачлалыг; эсхүл

(ii) Даргын хүлээн зөвшөөрөхүйц дүйцэх арга, техник болон практик аргачлалыг;

(4) ИНД-21-ийн К Бүлгийн шаардлагын дагуу материал, эд анги болон хэрэгслийг ашиглах;

(5) энэ зүйлийн (3)-т заасны дагуу ажлын гүйцэтгэлийг бататгахад шаардлагатай багаж, төхөөрөмж болон тестийн төхөөрөмжийг ашиглах;

(6) тухайн тест хийгдэж байгаа бүрдэл хэсэг нь нислэгт тэнцэх нөхцөлд байгааг бататгах зорилгоор, үйлдвэрлэгчийн зөвлөсөн тестийн төхөөрөмжийг, эсхүл тухайн тест хийж байгаа этгээдэд ижил боломжийг олгох, дүйцэх тестийн төхөөрөмж ашиглах;

(7) хэрэв техник үйлчилгээний журамд заасан бол, үйлдвэрлэгчийн зөвлөсөн тусгай тестийн төхөөрөмж, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх тестийн төхөөрөмж ашиглах;



- (8) тухайн техник үйлчилгээг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь хамааралтай НТЧ-ын бүх шаардлагыг хангаж байгааг бататгах хүртэл хийх;
- (9) техник үйлчилгээ дуусахад, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн төлөв байдал нь ашиглалтад шилжүүлэх шаардлага хангасан ба эх загварын, эсхүл зохих ёсоор сайжруулалт хийгдсэн нөхцөлтэй тэнцүү, эсхүл түүнээс доошгүй байгааг дараах чиглэлээр бататгах:
- (i) аэродинамикийн ажиллагаа;
  - (ii) бүтцийн бат бэх байдал;
  - (iii) чичиргээ болон элэгдэл гэмтлийг эсэргүүцэх чадвар;
  - (iv) НТЧ-т нөлөөлж байгаа бусад чанарууд;
- (10) техник үйлчилгээ дуусахад агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь дуу чимээний хязгаарлалт болон хөдөлгүүрийн хийн ялгаруулалтын холбогдох гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангаж байгааг бататгах;
- (11) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээний ажлаас тухайн этгээд дараах байдлаар чөлөөлөгдөж амарснаас бусад тохиолдолд техник үйлчилгээ хийхгүй байх:
- (i) тухайн техник үйлчилгээг хийхийн өмнөх 24 цагийн хугацаанд дараалсан 8-аас доошгүй цаг амарсан;
  - (ii) тухайн техник үйлчилгээг хийхийн өмнөх 30 хоногийн хугацаанд дараалсан 24 цагаас доошгүй хугацаагаар, 4-өөс доошгүй удаа амарсан.

#### **43.54. ИНД-145-ын дагуу шаардсан техник үйлчилгээ**

(a) Аливаа этгээдийг (хууль болон ИНД-145-ын дагуу Даргын олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнээс бусад тохиолдолд) дараах техник үйлчилгээ хийх, эсхүл ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) 5700кг-аас дээш МСТOW-тэй, эсхүл аливаа шаардсан багийн гишүүний суудлыг оролцуулахгүйгээр 10, эсхүл түүнээс дээш гэрчилгээжсэн зорчигчийн суудлын конфигурацитай агаарын хөлөгт, хэрэв тухайн агаарын хөлгийг дараах зорилгоор ашигладаг бол:
- (i) хууль болон ИНД-119-ийн дагуу Даргын олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд; эсхүл
  - (ii) хууль болон ИНД-115-ын дагуу Даргын олгосон Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд (халуун агаарын бөмбөлгөөс бусад); эсхүл
- (2) энэ хэсгийн (1)-д заасан агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл суурилуулахаар зорьж байгаа бүрдэл хэсэгт.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, этгээдийг (хууль болон ИНД-145-ын дагуу Даргын олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд зааснаас бусад тохиолдолд) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт дараах аливаа төрлийн техник үйлчилгээ хийх, эсхүл тухайн техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) бүрдэл хэсгийн их засвар;
- (2) хэрэв НТЧ-ын хадгалалтын холбогдох зааварчилгаанд үйлдвэрлэгч зөвшөөрсөн, эсхүл баталсан, эсхүл Даргын зөвшөөрсөн хэв (jig) ашиглахыг шаардсан бол, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээ;
- (3) хэрэв тухайн техник үйлчилгээнд бенч тест хийсэн байдлаар нийлүүлдэг нэгжийн бүрдэл хэсгийн аль нэг хэсгийн задаргаа хийх бол, бүрдэл хэсгийн техник үйлчилгээг дараахаас бусад тохиолдолд, хэрэв:
  - (i) ашиглалтын явцад ердийн аргаар тохируулах, эсхүл солих боломжтой эд ангийн бүрэлдэхүүн хэсгийг солих, эсхүл тохируулах зорилгоор задаргаа хийх;
  - (ii) тухайн хэвийн байдлыг нь өөрчилсөн эд ангийн дараагийн үйл ажиллагааг шалгахад ашигладаг тестийн хэрэгслээс өөр, нэмэлт тестийн хэрэгсэл ашиглахгүйгээр эд ангийн хэвийн ажиллагааг шалгадаг;
- (4) хэрэв тухайн техник үйлчилгээнд дараах ажил багтдаг бол, агаарын хөлгийн хөдөлгүүрийн техник үйлчилгээ:
  - (i) цилиндр, эсхүл поршинт иж бүрдэлд нэвтрэх зай гаргах зорилгоор задлах болон угсрахаас бусад, поршинт хөдөлгүүрийг задлах болон угсрах; эсхүл
  - (ii) хэрэв хөдөлгүүрийн НТЧ-ын хадгалалтын зааварчилгаа нь солих зааварчилгааг агуулсан ба хөдөлгүүрийн үндсэн гадаргууг, эсхүл эргэх иж бүрдлийг солих зорилгоор задлах, угсрах болон тухайн хөдөлгүүрийн үндсэн гадаргуугийн, эсхүл үндсэн эргэх иж бүрдлийг солиход зөвхөн үндсэн гадаргуугийн холбоосыг салгаснаар хийж болдог байхаас бусад тохиолдолд, турбинт хөдөлгүүрийн үндсэн гадаргуу, эсхүл эргэх иж бүрдлийг задлах болон угсрах; эсхүл
  - (iii) хурдны хайрцагт задаргаа хийх;
- (5) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан зааварчилгааны дагуу хийх сэнсний динамик балансаас бусад, сэнсний баланс хийх;
- (6) хэрэв тухайн техник үйлчилгээ нь аливаа дамжуулах хурдны хайрцгийг задлахтай холбоотой бол нисдэг тэргэнд хийх техник үйлчилгээ, хэрэв дотор талын үзлэг хийх зай гаргах зорилгоор гадаргууг салгахаар задлах тухайн задаргааг үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу хийдэг бол.

(c) Энэ зүйлийн (b) нь Чөлөөт нисэхийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлгөөс бусад, дараах агаарын хөлөгт хамаарахгүй:

- (1) хууль болон ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу Даргын олгосон *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөг; эсхүл

- (2) микролайт агаарын хөлөг; эсхүл
- (3) глайдер, эсхүл мото-глайдер; эсхүл
- (4) халуун агаарын бөмбөлөг.

#### **43.55. Их засварын бүртгэл хөтлөх**

Аливаа этгээдийг ИНД-д шаардсан агаарын хөлөг, их бие, хөдөлгүүр, сэнс, эсхүл агаарын хөлгийн бусад бүрдэл хэсэгт их засвар хийсэн бичилтийг дараахаас бусад тохиолдолд, аливаа техникийн баримт бичигт оруулахыг хориглоно:

- (1) Даргын хүлээн зөвшөөрөхүйц арга болон техник ашиглан задалсан, цэвэрлэсэн, үзлэг хийсэн болон шаардлагатай засвар хийж угсарсан;
- (2) дараах тест хийсэн:
  - (i) ИНД-21-ийн дагуу олгосон маягийн гэрчилгээ, нэмэлт маягийн гэрчилгээ, эсхүл бусад, үйлдвэрлэлийн зөвшөөрөл эзэмшигчийн боловсруулж баримтжуулсан, Даргын хүлээн зөвшөөрөхүйц хүчинтэй стандарт болон техникийн өгөгдлийн дагуу; эсхүл
  - (ii) Даргын баталсан бусад стандарт, эсхүл техникийн өгөгдлийн дагуу.

#### **43.57. Нөөц**

#### **43.59. Радио станцын тест болон үзлэг**

ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн радио станцын үзлэг хийх этгээд нь Хавсралт В-д заасан тест болон үзлэгийг хийж гүйцэтгэнэ.

#### **43.61. Өндөр-хэмжигч системийн тест болон үзлэг**

ИНД-91-ээр шаардсан агаарын хөлгийн өндөр-хэмжигч системийн үзлэг хийх этгээд нь Хавсралт D-д заасан тест болон үзлэгийг хийж гүйцэтгэнэ.

#### **43.63. SSR транспондерийн тест болон үзлэг**

ИНД-91-ээр шаардсан, SSR транспондерийн үзлэг хийх этгээд нь Хавсралт E-д заасан тест болон үзлэгийг хийж гүйцэтгэнэ.

#### **43.65. Ослын байршил дамжуулагч (ELT), агаарын хөлгийн ослын байршлийн системийн (AELS) тест болон үзлэг**

ИНД-91-ийн G Бүлгийн дагуу шаардсан ELT, эсхүл AELS-ийн тест болон үзлэг хийх этгээд нь Хавсралт F-д заасан холбогдох тест болон үзлэгийг хийх үүрэгтэй.

**43.67. Үл эвдэх сорил**

Холбогдох техник үйлчилгээний өгөгдөл нь шингэн нэвчүүлэх, соронзон бөөм, хуйларсан гүйдэл, хэт авиа, эсхүл радиографийн аргыг ашиглан үл эвдэх сорилын тест хийхийг шаардсан бол, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх аливаа этгээд нь:

- (1) тухайн ашиглаж байгаа арга техникт тохирсон, үзлэгийн эрх олгох зөвлөлөөс (CBIP) олгосон гэрчилгээтэй, эсхүл түүнтэй дүйцэх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц гэрчилгээ эзэмшдэг байна;
- (2) тухайн үл эвдэх сорилыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц тохирох арга, техник болон практик аргачлал ашиглан хийнэ.

**43.69. Техник үйлчилгээний бүртгэл хөтлөх**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээ хийх этгээд нь тухайн техник үйлчилгээ дууссаны дараа, дараах мэдээллийг зохих MLB-т оруулах үүрэгтэй:

- (1) хэрэв хамааралтай бол, техник үйлчилгээний дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
  - (i) аливаа хийсэн үзлэгийн таних тодорхойлолтыг;
  - (ii) тухайн гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг;
  - (iii) тухайн ашигласан техникийн өгөгдлийг;
  - (iv) хэрэв тухайн техник үйлчилгээ нь 43.103(a)(4)-ийн дагуу нислэгийн шалгалт шаарддаг бол, тухайн үйл ажиллагааны нислэгийн шалгалтын шаардлагыг;
- (2) хэрэв тухайн техник үйлчилгээний үед бүрдэл хэсгийг салгасан, эсхүл суурилуулсан бол:
  - (i) тухайн бүрдэл хэсгийн тодорхойлолтыг;
  - (ii) түүний эд ангийн дугаар болон серийн дугаарыг, хэрэв байгаа бол;
  - (iii) тухайн холбогдох шилжүүлэх баримт бичгийн ишлэлийг;
- (3) тухайн техник үйлчилгээний хүрээнд газарт, эсхүл агаарт хийсэн тестийн үр дүнг багтаасан аливаа хэмжилт, эсхүл тестийн үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг;
- (4) өндөр-хэмжигч системийн тест болон үзлэгийн хувьд, тухайн өндөр-хэмжигчид тест хийсэн огноо болон максимум түвшинг;
- (5) хэрэв AD-ийг тухайн техник үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлсэн бол:
  - (i) тухайн AD дугаарыг;
  - (ii) тухайн өөрчлөлтийн огноог;
  - (iii) тухайн хэрэгжүүлэлтийн хэлбэрийг;
- (6) тухайн байрлал болон хэрэв хамааралтай бол, техник үйлчилгээг гүйцэтгэсэн байгууламжийн нэрийг;

(7) тухайн техник үйлчилгээг хийх болсон шалтгааныг.

(b) Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээг хийх этгээд нь дараах тохиолдолд, тухайн техник үйлчилгээний бүртгэл хийх зорилгоор холбогдох WS-ийг ашиглаж болно, хэрэв:

- (1) хийгдсэн техник үйлчилгээний нэгтгэсэн мэдээллийг зохих MLB-д бүртгэсэн бол;
- (2) энэ зүйлийн (b)(1)-ийн дагуу шаардсан техник үйлчилгээний нэгтгэсэн мэдээлэлд тухайн WS-г иш татсан бол.

(c) Агаарын хөлөгт техник үйлчилгээ хийх этгээд нь TLB-г бичиж оруулсан гэмтлийг арилгах, эсхүл TLB-д бичиж оруулсан тухайн үзлэгийг хийсний дараа:

- (1) тухайн техник үйлчилгээний гүйцэтгэлийг TLB-д бүртгэх;
- (2) энэ зүйлийн (a)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг зохих MLB-д бүртгэх; эсхүл
- (3) хэрэв MLB бэлэн байгаагүй бол, техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг техник үйлчилгээ хийсэн тухайн агаарын хөлгөөр тээвэрлэхээс бусад, өөр аливаа боломжит аргаар MLB хадгалагдаж байгаа газарт хүргэх үүрэгтэй.

(d) Агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэгт техник үйлчилгээ хийх этгээд нь энэ зүйлийн (a), (b), (c)-д шаардсан дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэсний дараа, техник үйлчилгээний бүртгэлд дараах мэдээллийг оруулах үүрэгтэй:

- (1) тухайн этгээдийн нэр;
- (2) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;
- (3) хэрэв хамааралтай бол, тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;
- (4) тухайн техник үйлчилгээг хийж дууссан огноо.

(e) ИНД-91.509(b)-д шаардсаны дагуу, ашиглалтын цаг бүртгэгчээр тоногдсон агаарын хөлөгт хуваарьт техник үйлчилгээ хийх этгээд нь тухайн техник үйлчилгээг хийж дууссаны дараа, дараах мэдээллийг зохих MLB-д бүртгэх үүрэгтэй:

- (1) тухайн ашиглалтын цаг бүртгэгчийн нийт заалтыг;
- (2) ашиглалтын цаг бүртгэгчийг сүүлчийн хуваарьт үзлэгээс хойш оролдож өөрчилсөн байж болох аливаа шинж тэмдгийг.

(f) Гүйцэтгэсэн техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэхийг энэ зүйлийн (a)-аас (e)-д шаардсан этгээд нь алдаагүй, тод гаргацтайгаар бэхээр, эсхүл бусад байнгын хувиршгүй хэлбэрээр бүртгэх үүрэгтэй.

## С Бүлэг - Ашиглалтад шилжүүлэх

### 43.101. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, энэ зүйлийн (c) болон 43.54-г харгалзан, дараах шаардлагыг хангаагүй этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) ИНД-66-гийн дагуу олгосон тохирох категори болон зэрэглэл бүхий хүчинтэй AMEL эзэмшдэг байх; эсхүл
- (2) хамааралгүй
- (3) ИНД-145-ын дагуу олгосон тохирох ангилал бүхий агаарын хөлгийн ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс, тухайн агаарын хөлөг, эсхүл эд ангийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх зөвшөөрөлтэй байх; эсхүл
- (4) ИНД-66-гийн дагуу олгосон, зохих баталгаажуулсан тэмдэглэл бүхий хүчинтэй MAC эзэмшдэг байх; эсхүл
- (5) Монгол Улсын гадна хийсэн техник үйлчилгээний хувьд, ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын эрхийн хүрээнд олгосон, Даргын хүлээн зөвшөөрөхүйц, тухайн маягийн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн зохих AMEL, эсхүл зөвшөөрөл эзэмшдэг байх; эсхүл
- (6) тухайн техник үйлчилгээг 43.51(b)-гийн дагуу хийсэн байх.

(b) Хэрэв глайдерын байгууллагаас глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх эрхийг тухайн этгээдэд олгосон бол, глайдер, эсхүл глайдерын бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж болно.

(c) Тухайн этгээдийг агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн техник үйлчилгээг хийх, хянах, эсхүл гэрчилгээжүүлэх ажлаас дараах байдлаар чөлөөлөгдөж амарснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийн өмнөх 24 цагийн хугацаанд дараалсан 8-аас доошгүй цаг амарсан;
- (2) ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийн өмнөх 30 хоногийн хугацаанд дараалсан 24 цагаас доошгүй хугацаагаар, 4-өөс доошгүй удаа амарсан.

### 43.103. Ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх шаардлага

(a) Аливаа этгээдийг дараахаас бусад тохиолдолд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) тухайн техник үйлчилгээг энэ Дүрмийн шаардлагын дагуу хийсэн бол;
- (2) тухайн этгээд нь 43.101-ийн шаардлагыг хангасан бол;

- (3) тухайн техник үйлчилгээний хувьд, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь ашиглалтад шилжүүлэхэд тохирч байгаа бол;
- (4) хэрэв агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлт, эсхүл үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөлж болох техник үйлчилгээг тухайн агаарын хөлөгт хийсэн бол:
- (i) ИНД-91.613-ын дагуу шаардлага хангасан нислэгийн үйл ажиллагааны шалгалтыг гүйцэтгэсэн ба нислэгийн шалгалтын гүйцэтгэлийг агаарын хөлгийн MLB-д, эсхүл WS болон TLB-д бүртгэсэн байх; эсхүл
  - (ii) газрын тест, үзлэг, эсхүл аль аль нь агаарын хөлгийн нислэгийн шинж чанарыг мэдэгдэхүйц өөрчлөөгүй, эсхүл нислэгийн үйл ажиллагаанд их хэмжээгээр нөлөөлөөгүй болохыг тодорхой харуулсан, газарт хийсэн тест болон үзлэгийн дэлгэрэнгүй мэдээллийг агаарын хөлгийн MLB-д, эсхүл WS-д бүртгэсэн байх; эсхүл
  - (iii) энэ зүйлийн (a)(4)(i)-ийн дагуу шаардсан үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор ашиглалтад шилжүүлсэн байх.
- (b) Дараах шаардлага хангаагүй этгээдийг, том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засвар хийсний дараа, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:
- (1) тухайн этгээд нь 43.101-ийн шаардлагыг хангасан байх;
  - (2) тухайн том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засвар нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлтэй нийцсэнийг E Бүлгийн дагуу гэрчилгээжүүлсэн байх;
  - (3) тухайн том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын хувьд, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь ашиглалтад шилжүүлэхэд тохирч байх;
  - (4) хэрэв энэ зүйлийн (b)(2)-ын дагуу хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөл нь тухайн нислэгийн зааврын үйл ажиллагааны хязгаарлалт, эсхүл нислэгийн өгөгдлийн өөрчлөлтийг агуулдаг бол, тухайн өөрчлөлтийг нислэгийн зааварт тусгасан байх.
- (c) Энэ зүйлийн (a)(4)(iii)-ын дагуу үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх үүрэг бүхий этгээд нь агаарын хөлгийн MLB, эсхүл WS болон TLB-д дараах мэдээллийг бүртгэх үүрэгтэй:
- (1) ашиглалтад шилжүүлэх дараах мэдэгдэл:
 

*“Тухайн бүртгэгдсэн ажлын хүрээнд, зөвхөн тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны нислэгийн шалгалт хийх зорилгоор ашиглалтад шилжүүлэв”;*
  - (2) тухайн ашиглалтад шилжүүлэх мэдэгдлийн дараа:
    - (i) тухайн этгээдийн нэр;
    - (ii) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;

- (iii) тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;
- (iv) тухайн бүртгэлийг оруулсан огноо.

#### **43.105. Техник үйлчилгээний дараа ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, техник үйлчилгээний дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь зохих MLB, эсхүл WS болон шаардлагатай бол, TLB-д 43.69-ийн дагуу бүртгэгдсэн байхыг шаардсан техник үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийг дараах мэдээллийн хамт бүртгэх үүрэгтэй:

- (1) тухайн этгээдийн нэр;
- (2) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;
- (3) тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;
- (4) тухайн бүртгэлийг оруулсан огноо;
- (5) ашиглалтад шилжүүлэх дараах мэдэгдэл, хэрэв MLB, WS, эсхүл TLB-д тогтсон хэлбэртэй дүйцэх мэдэгдэл байдаггүй бол:

*“Тухайн бүртгэгдсэн техник үйлчилгээг ИНД-43-ын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэсэн ба энэхүү техник үйлчилгээний хүрээнд (агаарын хөлөг)\* (бүрдэл хэсэг)\*-г ашиглалтад шилжүүлэв.”*

*\* - хамааралгүйг устгах*

(b) Хэрэв бүрдэл хэсэг нь агаарын хөлөгт суурилагдаагүй, эсхүл суурилуулахаар хуваарилаагүй бол, тухайн бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь дараах маягтын дагуу ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх үүрэгтэй:

- (1) *CAA Form One - шилжүүлэхийг зөвшөөрсөн гэрчилгээ, хэрэв:*
  - (i) тухайн техник үйлчилгээг ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд хийхийг 43.54-т шаардсан бол; эсхүл
  - (ii) тухайн бүрдэл хэсгийг ИНД-148-ын дагуу олгосон агаарын хөлгийн үйлдвэрлэгч байгууллагын гэрчилгээ, эсхүл ИНД-145-ын дагуу олгосон ТҮБ-ын гэрчилгээний нөхцөлийн дагуу экспортод гаргах бол; эсхүл
- (2) *CAA Form Two - Монгол Улсын эд ангийн дотоод шошго.*

#### **43.107. Ажиллагаагүй төхөөрөмж**

ИНД-91.537-гийн дагуу ажиллагаагүй байхыг зөвшөөрсөн хэрэглэл, эсхүл төхөөрөмжийг багтаасан, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх этгээд нь 43.105-ын дагуу шаардсан ашиглалтад шилжүүлэх мэдэгдэлд гарын үсэг зурахын өмнө дараах ажиллагааг хийх үүрэгтэй:



- (1) тухайн TLB-д ажиллагаагүй хэрэглэл болон төхөөрөмжийн жагсаалтыг тэмдэглэх;
- (2) бүх ажиллагаагүй хэрэглэлүүд дээр, тухайн ажиллагаагүй төхөөрөмжийн бүхээгийн удирдлагын хэсэг бүрийн дээр нь, эсхүл дэргэд нь “Ажиллагаагүй” (*Inoperative*) гэсэн зурагт хуудсыг байрлуулах.

#### 43.109. Гэмтэл

Энэ Дүрмийн хүрээнд агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх үүрэг бүхий этгээд нь, илэрсэн гэмтэл засагдаагүй шалтгаанаар тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлээгүй бол, тухайн агаарын хөлгийн дараагийн нислэгээс өмнө тухайн этгээд дараах үүрэгтэй:

- (1) тухайн гэмтлийн дэлгэрэнгүй мэдээллийг TLB-д бичиж оруулах, хэрэв тухайн гэмтлийг TLB-д бичиж оруулаагүй бол;
- (2) тухайн гэмтлийг зохих MLB-д бичиж оруулсныг бататгах, хэрэв боломжтой бол;
- (3) энэ зүйлийн (1) болон (2)-ын дагуу гэмтлийн дэлгэрэнгүй мэдээллийг бичиж оруулсны дараа тухайн этгээдийн:
  - (i) нэр болон гарын үсэг;
  - (ii) үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;
  - (iii) тухайн бүртгэлийг оруулсан огноог бичих.

#### 43.111. Нөөц

#### 43.113. Удирдлагын системийн аюулгүй байдлын давхар үзлэг

(a) Дараах шаардлага хангаагүй этгээдийг, тухайн агаарын хөлгийн удирдлагын систем, эсхүл бүрдэл хэсгийн удирдлагын аль ч системийн анхны угсралт болон задаргаа, эсхүл тохируулга хийсний дараа, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) С Бүлгийн холбогдох шаардлагыг хангасан байх;
- (2) дараах шаардлагыг бататгах аюулгүй байдлын давхар үзлэг хийсэн байх:
  - (i) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн удирдлагын систем, тухайлбал системийн ажиллагаа нь хэвийн байгааг;
  - (ii) хийгдсэн техник үйлчилгээний хүрээнд удирдлагын системийн угсралтыг зөв хийсэн бөгөөд бүх шаардлагатай түгжих механизм байрлалдаа байгааг;
- (3) энэ зүйлийн (c) болон (d)-д шаардсан гэрчилгээжүүлэлтийг хийж, гарын үсэг зурсан байх.

(b) Энэ зүйлийн (a)(2)-т шаардсан аюулгүй байдлын давхар үзлэгийг дараах этгээд гүйцэтгэх үүрэгтэй:

- (1) 43.101-д заасан, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэх шаардлагыг хангасан этгээд;
- (2) энэ зүйлийн (b)(1)-д заасан этгээдийн томилсон, аюулгүй байдлын үзлэг хийх зохих сургалтад хамрагдсан, зохих мэдлэг болон туршлагатай, дараах эрх эзэмшдэг этгээд:
  - (i) ИНД-66-гийн дагуу олгосон хүчинтэй AMEL; эсхүл
  - (ii) ИНД-66-гийн дагуу олгосон хүчинтэй MAC; эсхүл
  - (iii) ИНД-61-ийн дагуу олгосон, тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэл бүхий хүчинтэй нисгэгчийн үнэмлэх; эсхүл
  - (iv) ИНД-145-ын дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс олгосон хүчинтэй эрх; эсхүл
  - (v) ICAO-гийн Хэлэлцэн тохирогч улсын зохих эрхийн хүрээнд олгосон хүчинтэй AMEL, эсхүл хүчинтэй MAC; эсхүл
  - (vi) глайдерын байгууллагаас олгосон хүчинтэй глайдерын нисгэгчийн үнэмлэх, эсхүл инженерийн зөвшөөрөл.

(c) Энэ зүйлийн (b)(1)-д заасан этгээд нь дараах мэдээллийг зохих MLB, эсхүл WS-д бичиж оруулах үүрэгтэй:

- (1) үзлэг хийсэн удирдлагын системийг таних тэмдэглэгээг;
- (2) хийсэн аюулгүй байдлын үзлэгийн хүрээ ба хамарсан далайцын дэлгэрэнгүйг;
- (3) дараах мэдэгдлийг:

*“Бид, аюулгүй байдлын давхар үзлэгийг гүйцэтгэж, агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн тухайн удирдлагын систем нь зөв ажиллаж байгааг тогтоосон бөгөөд хийгдсэн техник үйлчилгээний хүрээнд удирдлагын системийг зөв угсарч түгжсэн болохыг гэрчилгээжүүлэв.”*

(d) Энэ зүйлийн (c)(3)-ын дагуу шаардсан мэдэгдлээс гадна, энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан тухайн этгээдийн дараах мэдээллийг зохих MLB, эсхүл WS-д бичиж оруулах үүрэгтэй:

- (1) тухайн этгээдийн нэр;
- (2) тухайн этгээдийн гарын үсэг, хэрэв MLB, эсхүл WS нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;
- (3) тухайн этгээдийн үнэмлэх, зөвшөөрөл, эсхүл эрхийн дугаар;
- (4) тухайн бичилт хийсэн огноо.

**43.115. Хөдөлгүүрийн үзүүлэлтийн шалгалт**

(а) Энэ зүйлийн (с)-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг дараах техник үйлчилгээний ажлын дараа хөдөлгүүрийн үзүүлэлтийн шалгалтыг тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу хийснээс бусад тохиолдолд, агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) 100 цагийн, эсхүл агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн гаргасан техник үйлчилгээний хуваарийн дагуу хийсэн дүйцэх үзлэг;
- (2) хөдөлгүүр солилт;
- (3) сэнс солилт;
- (4) аливаа бусад техник үйлчилгээ, хэрэв агаарын хөлгийн үйлдвэрлэгч нь техник үйлчилгээний дараа хөдөлгүүрийн үзүүлэлтийг шалгахыг зөвлөдөг бол.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан хөдөлгүүрийн үзүүлэлтийн шалгалтын дараа агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлж байгаа этгээд нь дараах мэдээллийг зохих MLB, эсхүл WS-д бүртгэгдсэн болохыг бататгах үүрэгтэй:

- (1) тухайн гадна орчны хэм болон атмосферийн даралт;
- (2) хөдөлгүүрийн үзүүлэлтийн шалгалтын үр дүнгийн дэлгэрэнгүй.

(с) Энэ зүйлийн (а) нь дараах техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу ашигладаг агаарын хөлөгт хамаарахгүй:

- (1) ИНД-119-ийн дагуу батлагдсан; эсхүл
- (2) ИНД-91.607-гийн дагуу батлагдсан.

**D Бүлэг - Нислэгт тэнцэх чадварын үнэлгээ****43.151. Үнэлгээ хийх этгээд**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, тухайн этгээдэд ИНД-66-гийн дагуу IA олгоогүй бол, агаарын хөлгийн НТЧ-ын үнэлгээ хийхийг хориглоно.

(b) Дараах шаардлагыг хангасан этгээд глайдерын НТЧ-ын үнэлгээ хийж болно, хэрэв:

- (1) тухайн этгээдийг глайдерын байгууллагаас глайдерын НТЧ-ын үнэлгээ хийхийг зөвшөөрсөн бол;
- (2) тухайн этгээд нь, агаарын хөлөг болон бүрдэл хэсэг нь ИНД-д нийцэж байгаад үзлэг хийх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц сургалтад хамрагдаж, шалгалтад хангалттай дүн үзүүлсэн бол.

**43.153. Үнэлгээний шаардлага**

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, ИНД-91.615-д шаардсан агаарын хөлгийн НТЧ-ын үнэлгээ хийж байгаа этгээд нь үнэлгээ хийснийг баталгаажуулахын өмнөх 30 хоногийн дотор дараах ажлыг хийсэн байх ёстой:

- (1) тухайн агаарын хөлөг нь түүний маягийн гэрчилгээний техникийн өгөгдлийн хуудастай, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц, дүйцэх маягийн өгөгдөлтэй нийцэж байгааг шалгах;
- (2) ИНД-91-ийн F Бүлэгт шаардсан хэрэглэл болон төхөөрөмж бүрийг суурилуулсныг шалгах;
- (3) ИНД-91.509(b)-гийн дагуу ашиглалтын цаг бүртгэгчээр тоногдсон байхыг шаардсан агаарын хөлгийн хувьд:
  - (i) ашиглалтын цаг бүртгэгчийн заалтыг зохих MLB-д бүртгэх;
  - (ii) тухайн TLB-д бүртгэгдсэн агаарын хөлгийн нийт ашиглалтын цагийг ашиглалтын цаг бүртгэгчийн заалттай харьцуулах;
  - (iii) энэ зүйлийн (a)(3)(ii)-ын дагуу тогтоосон агаарын хөлгийн нийт ашиглалтын цагтай холбоотой аливаа үл тохирол, зөрүүг 43.155(a)(4)-т шаардсан тайланд оруулсныг бататгах;
- (4) сүүлчийн НТЧ-ын үнэлгээ, эсхүл НТЧ-ын гэрчилгээ олгох үзлэгээс хойш хийсэн дараах ажлыг шалгах:
  - (i) бүх модификаци болон засварын ажил зөв бүртгэгдсэн бөгөөд ИНД-21-ийн Хавсралт D-д заасан холбогдох техникийн өгөгдлийг иш татан, ашиглалтад шилжүүлэх гэрчилгээжүүлэлтийг зөв хийснийг;
  - (ii) холбогдох техник үйлчилгээний хөтөлбөрт тусгагдсан, хугацаа нь болсон бүх техник үйлчилгээ зөв бүртгэгдсэн бөгөөд ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлснийг;
  - (iii) тухайн агаарын хөлгийн маяг болон түүнд суурилагдсан бүрдэл хэсэгт хамааралтай бүх AD-г үнэлж дүгнэсэн, 'хэрэгжүүлсэн', 'хэрэгжүүлсэн болохыг тогтоосон', эсхүл 'хамааралгүй' болохыг гэрчилгээжүүлсэн ба хэрэв AD нь давтан гүйцэтгэлтэй бол, холбогдох MLB-ийн 'давтагдах' хэсэгт бүртгэснийг;
  - (iv) TLB-д бүртгэгдсэн бүх гэмтлийг зассан ба тухайн агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлсэн, эсхүл тухайн гэмтэлтэй хэрэглэл болон төхөөрөмж TLB-д бүртгэгдсэн ба ИНД-91.537-д заасны дагуу ажиллагаагүй байж болохыг нь зөвшөөрсөн бол "ажиллагаагүй" гэсэн зурагт хуудас байрлуулсныг;
  - (v) ашиглалтад шилжүүлэх холбогдох бүх ажил хийгдсэн ба C Бүлгийн дагуу гэрчилгээжүүлснийг;

- (vi) тухайн бүртгэгдсэн жин, төвлөрөлтийн өгөгдөл нь агаарын хөлгийн жин болон төвлөрөлтийн бүх өөрчлөлтийг тусгасан бөгөөд бүртгэгдсэн жин, төвлөрөлтийн өгөгдөл нь тухайн агаарын хөлгийн заасан жин болон төвлөрөлтийн хязгаарлалтын хүрээнд байгааг;
- (vii) тухайн нислэгийн заавар болон түүнд хамааралтай холбогдох бүх нэмэлт нь агаарын хөлгийн тухайн үеийн төлөв байдалд нийцсэн, хүчинтэй хувилбар болохыг;
- (5) ашиглалтын хязгаарлалттай бүрдэл хэсэг бүрийн их засварын болон ашиглалтын хугацааг бүртгэсэн ба тэдгээр нь холбогдох үйлдвэрлэгчийн баримт бичигт тогтоосон хязгаарлалтын хүрээнд байгааг шалгах, хэрэв боломжтой бол, серийн дугаарыг бодит үзлэгээр бататгах;
- (6) тухайн агаарын хөлгийн ерөнхий төлөв байдлын үзлэг хийх.
- (b) Энэ зүйлийн (a)(1) болон (a)(4)(i)-д заасан шаардлага нь ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу олгосон *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт хамаарахгүй.
- (c) НТЧ-ын үнэлгээ хийж байгаа этгээд нь тухайн үнэлгээний явцад илрүүлсэн аливаа шинэ гэмтлийг TLB болон зохих MLB-д бүртгэх үүрэгтэй.

#### 43.155. Үнэлгээг баталгаажуулах

- (a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, тухайн агаарын хөлгийн НТЧ-ын үнэлгээ хийж байгаа этгээд нь тухайн үнэлгээ хийсний дараа, дараах үүрэгтэй:
  - (1) дараах мэдэгдлийг зохих MLB-д бичиж оруулснаар тухайн үнэлгээг хийснийг баталгаажуулах:
 

*“Миний бие, энэхүү агаарын хөлөгт НТЧ-ын (жилийн)\* (хоёр жилийн)\* үнэлгээ хийсэн бөгөөд ИНД 43.153(a)-д заасан шаардлагыг хангаж байгааг баталгаажуулж байна”;*

\* хамааралгүйг устгах
  - (2) тухайн мэдэгдлийн дараа:
    - (i) тухайн этгээдийн нэр;
    - (ii) тухайн этгээдийн гарын үсэг, MLB нь электрон хэлбэртэй байхаас бусад тохиолдолд;
    - (iii) тухайн этгээдийн IA-ийн дугаар;
    - (iv) тухайн үнэлгээ хийж дууссан огноог бичиж оруулах;
  - (3) энэ зүйлийн (c)-д заасан, дараагийн НТЧ-ын үнэлгээг хийхээр тогтоосон, үлдсэн хугацааг TLB-д бичиж оруулах;
  - (4) үнэлгээний тайланг Даргын хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрээр, дараах хугацаанд Даргад хүргүүлэх:
    - (i) энэ зүйлийн (1) болон (2)-т заасан тухайн үнэлгээг хийж гэрчилгээжүүлснээс хойш 7 хоногийн дотор; эсхүл

(ii) хэрэв энэ зүйлийн (1) болон (2)-т заасан тухайн үнэлгээг хийж гэрчилгээжүүлээгүй бол, тухайн үнэлгээг хийхээр 43.153(а)-д заасан 30 хоног дууссанаас хойш 7 хоногийн дотор.

(b) ИНД-91.537-д заасан ажиллагаагүй байж болохыг зөвшөөрсөн хэрэглэл, эсхүл төхөөрөмжтэй байгаагаас бусад тохиолдолд, агаарын хөлөгт НТЧ-ын үнэлгээ хийж байгаа этгээдийг, гэмтэл бүрийг зассан болон тухайн агаарын хөлгийг С Бүлэгт заасны дагуу ашиглалтад шилжүүлэхээр гэрчилгээжүүлснээс бусад тохиолдолд, тухайн үнэлгээг баталгаажуулахыг хориглоно.

(c) ИНД-91.615(а)(1), эсхүл 91.615(аа)-д заасан, дараагийн НТЧ-ын үнэлгээ нь дор заасан хугацаанаас 1 жил, эсхүл 2 жилээс их байх ёсгүй:

- (1) энэ зүйлийн (а), эсхүл 91.615(аа)-ийн дагуу тухайн үнэлгээг гэрчилгээжүүлсэн өдрөөс хойш; эсхүл
- (2) тухайн сунгалтын хугацаа эхлэх өдрөөс хойш, хэрэв тухайн үнэлгээг хийх тогтоосон, үлдсэн хугацааг ИНД-91.615(с)(1)-ийн дагуу сунгасан бол.

## **Е Бүлэг - Том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа тохирлыг гэрчилгээжүүлэх**

### **43.201. Зорилго**

Энэ бүлэг нь том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа, ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу стандарт, эсхүл хязгаарлагдмал категорийн НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлөг нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлэх зохицуулалтын шаардлагыг тогтооно.

### **43.203. Тохирлыг гэрчилгээжүүлэх этгээд**

(а) Дараах шаардлага хангаагүй этгээдийг, том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсэг нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлэхийг хориглоно:

- (1) ИНД-66-гийн Е Бүлгийн дагуу олгосон IA-ийн гэрчилгээ эзэмшдэг байх; эсхүл
- (2) ИНД-145-ын дагуу ТҮБ-ын гэрчилгээ эзэмшигчээс олгосон, тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн тохирлыг гэрчилгээжүүлэх эрх эзэмшдэг байх; эсхүл
- (3) агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн үйлдвэрлэгчээс тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн тохирлыг гэрчилгээжүүлэх зөвшөөрөлтэй байх.

(b) Энэ зүйлийн (а)-д заасныг үл харгалзан, этгээд нь том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа глайдер, эсхүл түүний бүрдэл хэсэг нь хүлээн зөвшөөрөхүйц техникийн өгөгдөлд тохирч байгааг гэрчилгээжүүлж болно, хэрэв тухайн этгээд нь дараах шаардлагыг хангасан бол:

- (1) глайдерын байгууллагаас глайдер болон глайдерын бүрдэл хэсгийн тохирлыг гэрчилгээжүүлэхийг зөвшөөрсөн;

- (2) ИНД-66-гийн Е Бүлэгт шаардсан IA-ийн гэрчилгээ олгох шаардлагатай дүйцэх, Даргын хүлээн зөвшөөрөхүйц зааварчилгааны сургалтад хамрагдаж, глайдер болон глайдерын бүрдэл хэсэгт үзлэг хийх шалгалтад тэнцсэн.

#### **43.205. Гэрчилгээжүүлэх шаардлага**

Том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсгийн тохирлыг гэрчилгээжүүлэх этгээд нь, түүний үр дүнг гэрчилгээжүүлэхийн өмнө, тухайн модификаци, эсхүл засвар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц, эсхүл баталсан холбогдох техникийн өгөгдөлд тохирч байгааг бататгана.

#### **43.207. Гэрчилгээжүүлэлт**

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, том хэмжээний модификаци, эсхүл том хэмжээний засварын дараа агаарын хөлөг, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсэг нь 43.205-д шаардсан холбогдох техникийн өгөгдөлтэй нийцэж байгааг гэрчилгээжүүлэх аливаа этгээд нь САА 337 маягтыг бөглөж, хувийг тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ эзэмшигчид хүргүүлнэ.

(b) ИНД-145-ын дагуу гэрчилгээжсэн ТҮБ нь энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг бүртгэхдээ САА 337 маягтаас өөр бичиг баримт ашиглаж болно.

(c) САА 337 маягтын дагуу тохирлыг гэрчилгээжүүлж байгаа этгээд нь гүйцэд бөглөсөн маягтын хувийг гэрчилгээжүүлснээс хойш 7 хоногийн дотор Даргад хүргүүлнэ.

## **F Бүлэг - Тусгай категорийн агаарын хөлгийн техник үйлчилгээ**

#### **43.301. Зорилго**

Энэ Бүлэг нь, ИНД-21-ийн Н Бүлгийн дагуу *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээ олгогдсон агаарын хөлгийн техник үйлчилгээний талаарх В болон С Бүлгийн шаардлагад нэмэлт, эсхүл үл хамаарах шаардлагыг тогтооно.

#### **43.303. Техник үйлчилгээний гүйцэтгэл**

Энэ дүрмийн 43.53-ын шаардлагад нэмж, *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөг, эсхүл *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл суурилуулахаар зорьж байгаа эд ангид ИНД-91.605-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу техник үйлчилгээ хийх этгээд нь:

- (1) техник үйлчилгээний хөтөлбөрийн эхэнд, энэ зүйлийн (2)-ын дагуу шаардсан үзлэгийн үеэр илрүүлэх магадлал бага аливаа гэмтэл, эсхүл конфигурацийн хэвийн бус байдлыг илрүүлэх үзлэгийг тухайн агаарын хөлөгт хийх;
- (2) анхны үзлэгийн дараа, хуваарьт үзлэг болон нарийвчилсан үзлэгийг техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хийх үүрэгтэй.

**43.305. Их засварын бүртгэл хөтлөх**

(а) Энэ Дүрмийн 43.55-д заасныг үл харгалзан, энэ зүйлийн (b)-г харгалзан, этгээд нь *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс, эсхүл агаарын хөлгийн бүрдэл хэсэгт их засвар хийсэн бөгөөд хэрэв энэ нь дараах баримт бичигт тусгасан арга, техникийг ашиглан задалсан, цэвэрлэсэн, үзлэг хийсэн, шаардлагатай засвар хийсэн, угсарсан, тест хийсэн бол, тухайн агаарын хөлгийн зохих техник үйлчилгээний баримт бичигт бичилт хийж болно:

- (1) тухайн агаарын хөлөг, эсхүл бүрдэл хэсгийн үйлдвэрлэгчийн; эсхүл
- (2) Даргын хүлээн зөвшөөрөхүйц, цэргийн эрх бүхий байгууллагын стандарт.

(b) *Тусгай категорийн үзүүлбэрийн* НТЧ-ын гэрчилгээ, эсхүл *тусгай категорийн хязгаарлагдмал* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлгийн хувьд, энэ зүйлийн (a)(1) болон (a)(2)-т шаардсан арга, техникийг ИНД-91.605-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрт тусгасан байх ёстой.

**43.307. Техник үйлчилгээний бүртгэл хөтлөх**

Энэ Дүрмийн 43.69(a)(2)(iii)-т заасныг үл харгалзан, *тусгай категорийн* НТЧ-ын гэрчилгээтэй агаарын хөлөгт техник үйлчилгээ хийж байгаа этгээд нь тухайн техник үйлчилгээг дууссаны дараа аливаа сольсон эд анги, эсхүл бүрдэл хэсэг бүрд дараах ишлэлийг бүртгэх үүрэгтэй:

- (1) тухайн эд анги, эсхүл бүрдэл хэсгийн гарал үүсэл;
- (2) тухайн эд анги, эсхүл бүрдэл хэсгийн эх үүсвэр;
- (3) тухайн эд анги, эсхүл бүрдэл хэсгийг дагалдах баримт бичиг;
- (4) тухайн эд анги, эсхүл бүрдэл хэсгийн түүх.



## Хавсралт А - 43.51(b)-гийн дагуу техник үйлчилгээ хийх этгээд

### А.1. Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаг агаарын хөлөг

Хууль болон ИНД-119-ийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, эсхүл хууль болон ИНД-115-ын дагуу олгосон Чөлөөт нисэхийн гэрчилгээний эрхийн хүрээнд иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлөгт 43.51(b)-д заасан этгээд нь дараах техник үйлчилгээг хийж болно:

- (1) нээлхий, бүрээс, эсхүл хаалтыг авахаас бусад, задаргаа шаардахгүй тосолгоо болон түрхцийн ажил;
- (2) агаарын хөлгийн зай хураагуур солих;
- (3) гал хамгаалагч болон гэрэл солих;
- (4) дараах ажлыг багтаасан GPS-төхөөрөмжийн техник үйлчилгээ:
  - (i) GPS-ийн хүлээн авагчийг салгах болон суурилуулах, хэрэв хүлээн авагч нь хялбар салгах, залгах боломжтой бөгөөд дараагийн тест хийх боломжийг хүлээн авагчид өөрт нь үйлдвэрээс суулгасан, мөн салгалт, суурилуулалт хийх холбогдох мэдээлэл нь бэлэн байдаг бол;
  - (ii) GPS-ийн хүлээн авагчийн өгөгдлийн сангийн мэдээллийг тогтмол шинэчлэх.
- (5) хөдөлгүүрийн компрессорыг угаах, хэрэв:
  - (i) угаах төхөөрөмжийн суурилуулалт нь аливаа хөдөлгүүрийн үндсэн удирдлагын системд задаргаа хийхийг шаарддаггүй бол;
  - (ii) угаах төхөөрөмжийн суурилуулалт болон салгалт, мөн хөдөлгүүрийг угаах болон хатаах үеийн хүйтэн эргүүлгийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг агуулсан, угаах ажиллагааны холбогдох мэдээлэл бэлэн байгаа бол.
- (6) суудал, хаалга болон зориулалтын нэмэлт төхөөрөмжийг суурилуулах ба салгах, хэрэв:
  - (i) тухайн төхөөрөмжийг суурилуулсан, эсхүл суурилуулаагүй үеийн агаарын хөлгийн конфигураци нь батлагдсан бол;
  - (ii) тухайн төхөөрөмжийг суурилуулсан, эсхүл салгасан үеийн конфигураци тус бүрийн жин болон төвлөрөлтийн өгөгдлийг агуулсан тухайн агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд хэрэгтэй мэдээлэл Нислэгийн зааварт багтсан бол;
  - (iii) тухайн төхөөрөмжийг суурилуулах болон салгах холбогдох мэдээлэл бэлэн байгаа бол;
  - (iv) тусгай багаж, тусгай төхөөрөмж, эсхүл дараагийн үзлэг шаардлагагүй бол.
- (7) хуваарьт техник үйлчилгээний хооронд давтан AD үзлэг хийх, хэрэв:
  - (i) AD үзлэгийг нисгэгч хийж болохыг заасан бол;

- (ii) AD-д заасан аливаа нөхцөлийг хангасан бол;
- (iii) тусгай багаж, эсхүл тусгай төхөөрөмж шаардлагагүй бол.
- (8) хөдөлгүүрийн тос нэмэх;
- (9) хэрэв тухайн агаарын хөлөг нь ИНД-91.537-д заасны дагуу ажиллагаагүй хэрэглэл болон төхөөрөмжтэй ажиллах боломжтой бол, тухайн ажиллагаагүй хэрэглэл болон төхөөрөмжтэй холбоотой гэмтлийн засварыг хойшлуулах;
- (10) тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс нисгэгч хийхээр тогтоосон, тусгай багаж, эсхүл төхөөрөмж шаарддаггүй тогтмол техник үйлчилгээ хийх;
- (11) 406МГц-ийн ELT-ийн өөрийгөө шалгах тест функцийг ажиллуулах.

## **А.2. Иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаггүй агаарын хөлөг**

Аливаа этгээд нь иргэний агаарын тээврийн үйл ажиллагаанд ашигладаггүй агаарын хөлөгт Хавсралт А.1- д заасан техник үйлчилгээний ажлаас гадна, 43.51(b)-д заасны дагуу дараах техник үйлчилгээг хийж болно:

- (1) газардах ангийн дугуй, эсхүл сүүлний гулгах ул (tail skid shoes) солих;
- (2) энгийн, эсхүл түр даавуун нөхөөсөн засвар, хэрэв:
  - (i) тухайн засвар нь аливаа нислэгийн удирдлагын гадаргууд хийгдээгүй бол;
  - (ii) тухайн засварыг хийхэд аливаа удирдлагын гадаргуу, эсхүл бүтцийн эд ангийн салгалт шаардлагагүй бол;
  - (iii) тухайн засварт стрингер, эсхүл нервюрийг өөрчлөх ажиллагаа ордоггүй бол;
- (3) хэрэв тухайн ажил нь дараах үйлдлийг хамрахгүй бол, гэмтсэн, эсхүл элэгдсэн бүрээс, будгийг сэргээх болон тусгаарлагч, эсхүл хамгаалалтын материалын бүрдэл хэсгийн түрхцийн ажил:
  - (i) аливаа үндсэн бүтцийг задлах, эсхүл салгах; эсхүл
  - (ii) аливаа ашиглалтын системд задаргаа хийх; эсхүл
  - (iii) удирдлагын гадаргууг сэргээх, хадгалах, эсхүл хамгаалах; эсхүл
  - (iv) тухайн агаарын хөлгийн их хэмжээний талбайг дахин будах;
- (4) бүрээс, эсхүл хүчилсэн бус бүтцийн таглах хавтанд энгийн, эсхүл түр засвар хийх;
- (5) гидравликийн шингэний саванд гидравлик шингэн нэмэх;
- (6) хөдөлгүүрийн тос солих;
- (7) тосны даралтын шугамын шүүрийг солих;
- (8) турбинт хөдөлгүүрийн очлуурыг салгах болон солих;
- (9) поршинт хөдөлгүүрийн очлуурыг салгах болон солих;
- (10) тормозны диск салгах болон солих.

## Хавсралт В - Агаарын хөлгийн радио станцын үзлэг

Энэ дүрмийн 43.59-д заасан этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) ашиглалтын түүхийн техник үйлчилгээний бүртгэл болон холбогдох техник үйлчилгээний дүрмийн шаардлагын хэрэгжилтийг шалгах;
- (2) суурь тавиур болон зөөллөгч суурийн холболт, тэдгээрийн эсэргүүцлийн максимум утга нь 0.05 Ом байгааг тест болон үзлэг хийж тогтоох;
- (3) төхөөрөмж хоорондын харилцан нөлөөллийг шалгах зорилгоор радио станцад бүхэлд нь тест болон үзлэг хийх;
- (4) аудио интеграц болон дотоод холбооны системд дараах шаардлагыг бататгах тест болон үзлэг хийх:
  - (i) дууны оролтын дохиогүй үед үлдэгдэл шуугианы түвшин 30дБ-ээс доош байгааг;
  - (ii) оролтын дохионы хэмжээ хэвийн үед зорилтот болон зорилтот бус гаралтын харьцаа 45дБ-ээс багагүй байгааг;
- (5) дараах системийн дамжуулах шугам болон антены VSWR-ын утга нь 3:1-ээс бага байгааг шалгах:
  - (i) хэт богино долгионы радио холбоо (VHF);
  - (ii) богино долгионы радио холбоо (HF) (T/R to antenna coupler);
  - (iii) зай хэмжих төхөөрөмж (DME);
- (6) дараах системийн сувагчлал зөв байгааг шалгах:
  - (i) хэт богино долгионы радио-холбоо (VHF);
  - (ii) богино долгионы радио-холбоо (HF) (T/R to antenna coupler);
  - (iii) хэрэглэлээр буулт үйлдэх систем (ILS);
  - (iv) бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч (VOR);
  - (v) зай хэмжих төхөөрөмж (DME);
- (7) хэт богино долгионы радио холбооны (VHF) системийн үзүүлэлт нь хэвийн ажиллагааг хангах хэмжээнд байгааг бататгах тест болон үзлэг хийх;
- (8) богино долгионы радио холбооны (HF) системд дараах шаардлагыг бататгах тест болон үзлэг хийх:
  - (i) антены бүрэн бүтэн байдал болон тусгаарлагчийн эсэргүүцэл зөвшөөрөгдөхүйц байгааг;
  - (ii) системийн үзүүлэлт нь хэвийн ажиллагааг хангах хэмжээнд байгааг;
- (9) радиокompасын (ADF) ажиллагаанд тест болон үзлэг хийх:
  - (i) мэдрэгч антены бүрэн бүтэн байдал болон тусгаарлагчийн эсэргүүцлийн тест хийх;
  - (ii) аудио ажиллагааны тест хийх;

- (10) хэрэглэлээр буулт үйлдэх системийн (ILS) хүлээн авагчийн ажиллагааг зөөврийн тестийн иж бүрдлээр шалгах, дараах шалгалтыг агуулсан тест болон үзлэг хийх:
- (i) модуляцийн алдааг заагч анхааруулах тэмдэг, курс болон глиссадын заалтын нарийвчлал, мэдрэмж болон курсийн сигналын өргөний тест хийх;
  - (ii) аудио ажиллагааны тест хийх;
- (11) бүх чиглэлд, хэт өндөр давтамжийн радио дохио дамжуулагч (VOR) системийн ажиллагааг зөөврийн тестийн иж бүрдлээр шалгах дараах шалгалтыг багтаасан тест болон үзлэг хийх:
- (i) модуляцийн алдааг заагч анхааруулах тэмдгийн тест хийх;
  - (ii) omni-radial resolving болон радио соронзон чиглэл заах хэрэглэлийн (RMI) нарийвчлалыг  $30^{\circ}$ -ын зайтайгаар бүх чиглэлд;
  - (iii) хөдөлгөөн хэмжигч, мэдрэмж болон курсийн сигналын өргөний сул явалтыг  $\pm 1^{\circ}$ -ын нарийвчлалтайгаар тест хийх;
  - (iv) аудио ажиллагааны тест хийх;
- (12) маркерын хүлээн авагчийн ажиллагааг зөөврийн тестийн иж бүрдлээр шалгах дараах шалгалтыг багтаасан тест болон үзлэг хийх:
- (i) 400, 1300 ба 3000Гц-ийн давтамж дээр дуут дохио болон холбогдох гэрлийн ажиллагаанд тест хийх;
  - (ii) хэрэв суурилагдсан бол, өндөр/нам мэдрэмжийн ажиллагааг шалгах;
- (13) зай хэмжих төхөөрөмжийн (DME) ажиллагааг зөөврийн тестийн иж бүрдлээр дараах шалгалтыг багтаасан тест болон үзлэг хийх:
- (i) хүрээний нарийвчлал болон газрын хурдны заалтад тест хийх;
  - (ii) аудио ажиллагаанд тест хийх.

## Хавсралт С - Нөөц

## Хавсралт D - Өндөр-хэмжигч системийн тест болон үзлэг

Энэ Хавсралт нь 43.61-д заасан этгээдэд хамаарна.

### D.1. Статик даралтын системийн тест:

- (a) Хуримтлагдсан чийг болон саадаар хязгаарлагдаагүй болохыг бататгана.
- (b) Битүүмжлэл нь дараах зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнд байгааг бататгана:
  - (1) битүүмжлэлгүй нисэх онгоцны хувьд:
    - (i) **Арга:** Аль нэг статик даралтын системийн статик сувгаар ойролцоогоор 1инч мөнгөн усны баганын дифференциал даралт үүсгэх, эсхүл өндөр-хэмжигч дээр тухайн тестийг хийж байгаа үеийн агаарын хөлгийн тухайн байршлын түвшин / өндөрлөгөөс дээш 300м (1000ft) заахаар даралтыг бууруулах;
    - (ii) **Зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээ:** Системийн даралтыг нэмэхгүйгээр 1 минутын турш байлгахад тухайн өндөр-хэмжигчийн үзүүлсэн түвшний заалтын алдаа нь 30м-ээс (100ft) хэтрэхгүй байх;
  - (2) битүүмжлэлтэй нисэх онгоцны хувьд:
    - (i) **Арга:** Статик системийн даралтыг, тухайн нисэх онгоцны маягаар гэрчилгээжсэн бүхээгийн максимум дифференциалтай дүйцэх дифференциал даралт хүртэл бууруулах;
    - (ii) **Зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээ:** Даралтыг нэмэхгүйгээр 1 минутын турш байлгахад үзүүлсэн түвшний заалтын алдаа нь тухайн бүхээгийн максимум дифференциал даралттай дүйцэх түвшний 2 хувь, эсхүл 30м-ийн (100ft) аль ихээс хэтрэхгүй байх.
- (c) Статик хүлээн авагчийн халаагуур ажиллагаатай болохыг тогтооно, хэрэв суурилуулсан бол.
- (d) Нислэгийн ямар ч нөхцөлд гадна орчны агаарын бодит статик даралт болон статик даралтын системийн агаарын даралт хоёрын хоорондын харьцаанд нөлөөлж болохуйц өөрчлөлт, эсхүл деформаци агаарын хөлгийн их биений гадаргууд үүсээгүй болохыг бататгана.

### D.2. Өндөр-хэмжигчийн тест:

- (a) Өөрөөр зааснаас бусад тохиолдолд, үзүүлэлтийг шалгах тест бүрийг хэрэглэл нь чичиргээтэй байхаар хийж болно.
- (b) Тест хийж байгаа орчны хэм нь ойролцоогоор 25°C-ийн гадна орчны хэмээс мэдэгдэхүйц ялгаатай байгаа тохиолдолд, тухайн тогтоосон нөхцөлд тохирох зөвшөөрөгдсөн зөрүүний хэмжээг тооцоолно.
- (c) Өндөр-хэмжигчийн тестийг дараах аргачлалын дагуу хийнэ:

**Хэмжээсийн алдаа:**

- (1) 1013,25мбар барометрийн даралтын хэмжээстэй өндөр-хэмжигч нь, Хүснэгт 1-д заасан түвшнээс, өндөр-хэмжигч суурилуулах агаарын хөлгийг ашиглахаар тооцоолсон максимум түвшин хүртэл харилцан хамааралтай даралтад амжилттай шалгагдсан байна;
- (2) Тест хийх цэгт ойролцоогоор 600м-ээс (2000ft) дотогш ойртох хүртэл даралтыг 1 минутад 6000м-ээс (20 000ft) ихгүй хурдтайгаар бууруулна;
- (3) Тест хийх цэг нь тухайн тестийн төхөөрөмжийн үечлэлтэй тохирсон байна;
- (4) Өндөр-хэмжигчийн заалтыг авахаас өмнө тест хийх цэг бүрд харилцан хамааралтай даралтад 10 минутаас хэтрүүлэлгүй, хамгийн багадаа 1 минут байлгана;
- (5) Тест хийх цэг бүр дээрх алдаа нь Хүснэгт 1-д заасан, зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнээс хэтрэхгүй байна;

**Хоцрох заалт:**

- (6) Энэ зүйлийн (с)(1)-ээс (с)(5)-д тодорхойлсон хэмжээсийн алдааны тестийн дээд хязгаарт харилцан хамааралтай даралтад өндөр-хэмжигч анх тест хийснээс хойш 15 минутын дотор өндөр-хэмжигч дээрх даралт дээр байхад хоцрох заалтын тестийг эхлүүлнэ;
- (7) Анхны тест хийх цэг буюу максимум түвшний 50%-тай тэнцэх түвшнээс 900м-ийн (3000ft) түвшин хүртэл, минутанд 1500м-ээс (5000ft) 6000м-ийн (20 000ft) хурдтайгаар өндөр алдаж байгаа байдлаар даралтыг өсгөнө;
- (8) Дараа нь тест хийх цэгт ойролцоогоор минутад 900м-ийн (3000ft) хурдтайгаар ойртоно;
- (9) Өндөр-хэмжигчийн тестийн заалтыг авахаас өмнө тухайн даралтад 15 минутаас хэтрүүлэлгүй, хамгийн багадаа 5 минут байлгана;
- (10) Заалтыг авсны дараа, хоёр дахь тест хийх цэг буюу максимум түвшний 40%-тай тэнцэх түвшинтэй харилцан хамааралтай даралт хүртэл өмнөхтэй адил аргачлалаар даралтыг нэмэгдүүлнэ;
- (11) Өндөр-хэмжигчийн тестийн заалтыг авахаас өмнө энэ даралтад 10 минутаас хэтрүүлэлгүй хамгийн багадаа 1 минут байлгана;
- (12) Үзүүлж байгаа заалтыг авсны дараа, даралтыг атмосферийн даралт хүртэл өмнөхтэй адил аргачлалаар нэмэгдүүлнэ;
- (13) Тест хийх хоёр цэг дээрх өндөр-хэмжигчийн үзүүлж байгаа заалт, энэ зүйлийн (b)(1)-ээс (b)(5)-д тодорхойлсон хэмжээсийн алдааг шалгах тест хийх үед тухайн цэгүүдэд харилцан хамааралтай түвшинд бүртгэгдсэн өндөр-хэмжигчийн заалтын зөрүү нь Хүснэгт 2-д заасан зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнээс илүү зөрүүтэй байж болохгүй.

**Нөлөөллийн дараа:**

- (14) Энэ зүйлийн (b)(6)-гаас (b)(13)-т заасны дагуу, заалт нь хоцрох тест хийсний дараах 5 минутын дотор уншигдсан атмосферийн даралтын аливаа өөрчлөлтийг зассан тухайн өндөр-хэмжигчийн заалт, тухайн жинхэнэ атмосферийн даралттай үеийн заалт нь Хүснэгт 2-д заасан зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнээс илүү зөрүүтэй байж болохгүй;

**Зууралт:**

- (15) Өндөр-хэмжигчийн даралтыг минутад ойролцоогоор 225м-ийн (750ft) тогтмол хурдтай бууруулахаар тохируулсан байна;
- (16) Хүснэгт 3-т заасан түвшин бүрд, чичиргээний дараа зүүний заалтад орох өөрчлөлт нь Хүснэгт 3-т заасан харилцан хамааралтай, зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнээс хэтрэхгүй байна;

**Битүүмжлэлийн алдагдал:**

- (17) Өндөр-хэмжигчийн хайрцгийн битүүмжлэл алдагдал нь доторх даралт 5400м-ийн (18 000ft) түвшний даралттай харилцан хамаарах үед, өндөр-хэмжигчийн тухайн заалт 1 минутын турш Хүснэгт 2-т үзүүлсэн зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнээс илүү өөрчлөгдөж болохгүй;

**Барометрийн хэмжээсийн алдаа:**

- (18) Тогтмол атмосферийн даралтад байхад, тухайн барометрийн даралтын хэмжээсийг даралтын утга бүр нь тухайн даралттай ижил байхаар Хүснэгт 4-т заасан түүний тохируулгын хязгаарын хүрээнд тохируулахад, тухайн заалт нь Хүснэгт 4-т үзүүлсэн дүйцэх түвшин бүрд 7.5м-ийн (25ft) зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнд заадаг байх ёстой.

(d) Тооцоолох системтэй агаарын өгөгдөхүүний компьютерийн (Air data computer) төрөл, эсхүл агаарын өгөгдөхүүнд өөртөө засвар хийдэг өндөр-хэмжигчийг үйлдвэрлэгчийн боловсруулсан техникийн тодорхойлолт болон хэлбэрээр тест хийж болно.

**D.3. Автоматаар даралтын түвшинг мэдээлэгч төхөөрөмж болон АТС транспондер системийн харилцан ажиллагааны тест**

- (a) Аливаа тест нь энэ зүйлийн (b)-д заасны дагуу хийгдэнэ.
- (b) АТС транспондер болон түвшин мэдээлэх өндөр-хэмжигчийн төхөөрөмжийг агаарын хөлөгт суурилуулсан байхад, түүний зориулалтын гүйцэтгэх ажиллагааг бататгах зорилгоор, "Mode C" горимд асуулга хийгдэж байх үед түүний автомат даралтын түвшний гаралтын утгыг хангалттай тооны тест хийх цэгүүдэд хэмжинэ.
- (c) Автомат мэдээлэгчийн мэдээлсэн болон өндөр-хэмжигчийн заасан түвшингүүдийн хоорондын зөрүү нь 37.5м-ээс (125ft) хэтэрч болохгүй.

**Хүснэгт 1 - Хэмжээсийн алдаа**

Түвшин	Дүйцэх даралт (мбар)	Зөвшөөрөгдөх зөрүүний	Түвшин	Дүйцэх даралт (мбар)	Зөвшөөрөгдөх зөрүүний
-1000	1050.406	20	14 000	595.239	100
0	1013.250	20	16 000	549.152	110
500	995.075	20	18 000	505.998	120
1000	977.166	20	20 000	465.633	130
1500	959.518	25	22 000	427.915	140
2000	942.129	30	25 000	376.009	155
3000	908.117	30	30 000	300.896	180
4000	875.105	35	35 000	238.423	205
6000	811.996	40	40 000	187.539	230
8000	752.624	60	45 000	147.477	255
10 000	696.817	80	50 000	115.972	280
12 000	644.408	90			

**Хүснэгт 2 -Тестийн зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээнүүд**

Тест	Зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээ ± (ft)
Битүүмжлэл алдагдлын тест	100
Эхний тест хийх цэг (максимум түвшний 50% )	75
Хоёр дахь тест хийх цэг (максимум түвшний 40% )	75
Нөлөөллийн дараах тест	30

**Хүснэгт 3 - Зөрүү**

Түвшин (ft)	Зөвшөөрөгдөх зөрүүний хэмжээ±/ (ft)
1000	70
2000	70
3000	70
5000	70
10 000	80
15 000	90
20 000	100
25 000	120
30 000	140
35 000	160
40 000	180
50 000	250

**Хүснэгт 4 - Даралтын түвшин**

Даралт (мбар)	Түвшин (ft)
951.55	-1727
965.10	-1340
982.03	-863
998.96	-392
1013.25	0
1032.82	+531
1046.37	+893
1049.41	+974



## Хавсралт Е - АТС Транспондерийн тест болон үзлэг

Энэ Хавсралт нь 43.63-д заасан этгээдэд хамаарна.

### Е.1. Ерөнхий зүйл

- (a) АТС транспондерт хийгдэх тестийг бенч шалгалт, эсхүл зөөврийн тестийн төхөөрөмж ашиглан хийж болно.
- (b) Хэрэв агаарын хөлгийн антены системд зөөврийн тестийн төхөөрөмжийг холбон ашиглаж байгаа бол, нислэгийн хөдөлгөөний удирдлагын радио маягийн системийн (АТСRBS) болзошгүй нөлөөллөөс зайлсхийх зорилгоор зөөврийн АТСRBS транспондерын тестийн төхөөрөмжийг нэг секундэд 235 асуулга илгээх хурдтайгаар ажиллуулна.
- (c) “Mode S”-ийн хувьд, тестийн төхөөрөмжийг секунд тутамд Mode S-ийн 50 асуулга илгээх хурдтайгаар ажиллуулна.
- (d) Зөөврийн тестийн төхөөрөмж ашиглан энэ дүрмийн Хавсралт Е.4(а)(3)-т заасны дагуу хүлээн авагчийн мэдрэмжийг хэмжсэн бол, антены холбоосонд гарах алдааг нөхөх зорилгоор нэмэлт 3дБ-ийн алдагдал тооцохыг зөвшөөрнө.

### Е.2. Радио хариултын давтамжийн тест

- (a) Бүх ангиллын АТСRBS транспондерын хувьд, тухайн транспондерт асуулга хийж, хариултын давтамж  $1090 \pm 3$  МГц байгааг бататгана.
- (b) 1В, 2В болон 3В ангиллын Mode S транспондерын хувьд, тухайн транспондерт асуулга хийж, хариултын давтамж  $1090 \pm 3$  МГц байгааг бататгана.
- (c) 1В, 2В, болон 3В ангиллын,  $1090 \pm 1$  МГц-ийн хариулах давтамжийн сонголттой Mode S транспондерын хувьд, тухайн транспондерт асуулга хийж, хариултын давтамж зөв байгааг бататгана.
- (d) 1А, 2А, 3А болон 4 ангиллуудын Mode S транспондерын хувьд, асуулга хийж, тухайн транспондерын хариултын давтамж нь  $1090 \pm 1$  МГц байгааг бататгана.

### Е.3. Suppression тест

- (a) 1В ба 2В ангиллын АТСRBS транспондер, эсхүл 1В, 2В болон 3В ангиллын Mode S транспондерыг Mode 3/A-ийн нэг секундэд 230-аас 1000 асуух хурдаар, эсхүл 1А ба 2А ангиллын АТСRBS транспондер, эсхүл 1В, 2А, 3А болон 4 ангиллын Mode S транспондерыг Mode 3/A-ийн нэг секундэд 230-аас 1200 асуух хурдаар асуух үед:
  - (1) P2 импульсийн далайц нь P1 импульстэй тэнцүү үед транспондер нь АТСRBS-ийн асуулгын 1%-иас илүүд хариулахгүй байгааг бататгах;
  - (2) P2 импульсийн далайц нь P1 импульсийн далайцаас 9дБ-ээр бага үед транспондер нь АТСRBS-ийн асуулгын 90%-д хариулт өгч байгааг бататгах.

(b) Хэрэв тухайн тестийг радио тест дохио ашиглан хийж байгаа бол, тухайн байрлалд дор дурьдсанаас өндөр асуулгын хурдтай тестийн төхөөрөмж ашиглахыг зөвшөөрснөөс бусад тохиолдолд, асуулгын хурд нь секундэд  $235\pm 5$  байна.

#### **E.4. Хүлээн авагчийн мэдрэмжийн тест**

(a) Бүх ангиллын ATCRBS транспондерын хувьд, тухайн системийн хүлээн авагчийн ажиллаж эхлэх минимум түвшин (triggering level) нь  $-73\pm 4\text{dbm}$ , эсхүл бүх ангиллын Mode S транспондерын хувьд, Mode S format (P<sub>6</sub> type) асуулгад хүлээн авагчийн ажиллаж эхлэх минимум түвшин нь  $-74\pm 3\text{dbm}$  байгааг тестийн иж бүрдэл ашиглан дараах аргаар бататгана:

- (1) дамжуулах шугамын антены төгсгөлд төхөөрөмжийг холбох; эсхүл
- (2) дамжуулах шугамын алдагдлыг тооцон транспондерын антены үүрэнд холбох; эсхүл
- (3) радио дохио ашиглах.

(b) Бүх ангиллын ATCRBS транспондер, эсхүл бүх ангиллын Mode S транспондерын хувьд, Mode 3/A болон Mode C маягийн хүлээн авагчийн мэдрэмжийн зөрүү нь 1db-ээс хэтрээгүйг бататгана.

#### **E.5. Радио давтамжийн гаралтын оргил чадлын тест**

Транспондерын радио-давтамжийн гаралтын чадлыг тухайн транспондерын ангилал тус бүрийн хувьд, дараах тогтоосон хязгаарт байгаа эсэхийг энэ хавсралтын E.4(a)-д заасан нөхцөлийг ашиглан бататгана:

- (1) 1A болон 2A ангиллын ATCRBS транспондерын хувьд, радио-давтамжийн гаралтын минимум чадал нь  $21.0\text{дБ*Вт}$ -аас ( $125\text{Вт}$ ) багагүй байна;
- (2) 1B болон 2B ангиллын ATCRBS транспондерын хувьд, радио-давтамжийн гаралтын минимум чадал нь  $18.5\text{дБ*Вт}$ -аас ( $70\text{Вт}$ ) багагүй байна;
- (3) 1A, 2A, 3A ба 4 ангиллын болон 1B, 2B ба 3B ангиллын өндөр гаралтын чадлын сонголттой Mode S транспондерын хувьд, радио-давтамжийн гаралтын минимум чадал нь  $21.0\text{дБ*Вт}$  ( $125\text{Вт}$ )-аас багагүй байна;
- (4) 1B, 2B болон 3B ангиллын Mode S транспондерын хувьд, радио-давтамжийн гаралтын минимум чадал нь  $18.5\text{дБ*Вт}$  ( $70\text{Вт}$ )-аас багагүй байна;
- (5) бүх ангиллын ATCRBS, эсхүл бүх ангиллын Mode S транспондерын хувьд, радио-давтамжийн гаралтын максимум чадал нь  $27.0\text{дБ*Вт}$ -аас ( $500\text{Вт}$ ) хэтрэхгүй байна;

#### **E.6. Mode S-ын сонгосон дамжуулах сувгийн тусгаарлалтыг тест**

Бүх ангиллын, сонгох ажиллагаатай Mode S транспондерын хувьд, сонгогдсон антенаас дамжуулсан радио-давтамжийн гаралтын чадал нь сонгогдоогүй антенаас дамжуулсан чадлаас хамгийн багадаа 20дБ-ээр илүү байгааг бататгана.

**E.7. Mode S-ын хаягийн тест**

Mode S транспондер руу зөв болон 2-оос доошгүй буруу хаягласан, секундэд 50 хэвийн асуулгын хурдтайгаар асуулга хийх ба зөвхөн хуваарилагдсан хаяглалтандаа хариу өгч байгааг бататгана.

**E.8. Mode S-ын форматын тест**

(a) Mode S транспондерыг тоноглогдсон “UF” форматаар нь асуух ба хариулт нь хяналтын UF=4 болон 5 гэсэн форматыг ашиглан зөв форматаар хариулж байгааг бататгана;

(b) UF=4 форматын хариултанд илтгэсэн түвшин нь хүчинтэй ATCRBS Mode S-ийн хариултанд илтгэсэн түвшинтэй адил байгааг бататгана;

(c) UF=5 форматад хариултанд илтгэсэн таних тодорхойлолт (identity) хүчинтэй ATCRBS Mode 3/A-гийн хариултанд илтгэсэнтэй адил байгааг бататгана, хэрэв транспондер нь UF=20, 21 болон 24 гэсэн холбооны форматыг ашиглан хариулахаар тоноглогдсон бол.

**E.9. Mode S-ын бүгдийг дуудах асуулгын тест**

Зөвхөн Mode S-ын бүгдийг дуудах асуулгын UF=11 формат болон ATCRBS /Mode S-ын бүгдийг дуудах форматаар (1.6 микросекунд P4 импульс) Mode S транспондероос асуулга хийж, хариултад зөв хаяглалт болон чадвар илтгэгдсэнийг бататгана. (DF=11 downlink format).

**E.10. Зөвхөн Mode SATCRBS-ын бүгдийг дуудах асуулгын тест**

Mode S транспондерт зөвхөн ATCRBS-н бүгдийг дуудах (0.8 микросекунд P4 импульс) асуулга хийн хариулт үйлдэхгүй байгааг бататгана.

**E.11. Mode S Squitter-ын тест**

Mode S транспондер нь ойролцоогоор секундэд нэг удаа зөв squitter-ийг үйлдэж байгааг бататгана.

## **Хавсралт F - Ослын байршил дамжуулагч (ELT), агаарын хөлгийн ослын байршлийн системийн (AELS) тест болон үзлэг**

Дараах тест болон үзлэгийг ИНД-91-ийн G Бүлэгт тодорхойлсон ELT, AELS-д тест болон үзлэг хийх шаардлагын хэрэгжүүлэлтийг бататгах зорилгоор 43.65-д заасан этгээдээр хийлгэсэн байх шаардлагатай:

- (1) ELT, эсхүл AELS, түүний бэхэлгээ болон антены холбоосонд зэврэлт, эсхүл зэврэлтийн үе давхарга байгаа эсэх болон ерөнхий нөхцөлийг тодорхойлох үзлэг хийх;
- (2) ELT, эсхүл AELS-ийн өөрийгөө шалгах тест функцийг ажиллуулж, ажиллагаа нь үйлдвэрлэгчийн зааврын дагуу шаардлага хангасан байгааг бататгах.

--oOo--